

“МОНГОЛЫН ШИЛДЭГ УРАН ЗУРГУУД” ТУСГАЙ ҮЗЭСГЭЛЭНГИЙН ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023.05.19

Дархан-Уул аймаг

Монголын Уран Зургийн Галерейгаас санаачлан Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газартай хамтран олон нийтийн урлагийн боловсролын цар хүрээ, хүртээмжийг сайжруулах, соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор 2019 оноос "Галерей аялж байна" хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд дөрөв дэх жилдээ зохион байгуулж байна. Энэ хүрээнд Дархан-Уул аймагт "ГАЛЕРЕЙ АЯЛЖ БАЙНА" хөтөлбөрийг 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 17-ны өдрүүдэд Монголын түүх соёлын хосгүй үнэт дурсгал болон сүүлийн 34 жил үзэгчдийн хүртээл болж байгаагүй сор бүтээлээр анх удаа аймгийн Залуучууд театрт зохион байгууллаа.

"ГАЛЕРЕЙ АЯЛЖ БАЙНА" хөтөлбөрийн хүрээнд

1. "Монголын шилдэг уран зургууд" нүүдлийн тусгай үзэсгэлэн
2. "Хөгжимтэй зураг" хөтөлбөр
3. "Хандлагааар анагаахуй" урлагийн сэтгэл заслын хөтөлбөр
4. "Цаг хугацаагаар аялагч" олон нийтийн оролцоот урлагийн бүтээлийг үзэгчдэд толилуулав.

2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 17-ны өдрүүдэд аймгийн Залуучууд театрын 1, 2 давхарт дээрх хөтөлбөрүүдийг зохион байгуулж 16-ны өдөр нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж том хүн 390, хүүхэд 536 нийт 926 үзэгчдэд хүргэлээ.



СУРТАЛЧИЛГАА:

2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс үзэсгэлэнтэй холбоотой постер, шторк танилцуулга зэргийг байгууллагын цахим сайт [Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар \(mos.gov.mn\)](http://mos.gov.mn), цахим сошиал [\(2\) Дархан-Уул аймгийн Соёл, урлагийн газар | Facebook](#) хуудсуудаар мэдээлэл түгээж ажиллалаа. Үүнд Соёлын яамнаас ирүүлсэн брэндбүүкийн дагуу бэлтгэн олон нийтэд нийт 75 фото мэдээ, 2 видео мэдээ бэлтгэн 8 мэдээ нийтэлж сурталчиллаа. Мөн аймгийн Залуучууд театрын гадна байрлах лед дэлгэцээр, орон нутгийн телевиз болох DBS телевиз, аймгийн Мэдээлэл технологийн алба, Дархын сумын хэвлэл

мэдээлэл, Монцаме агентлагийн Дархан дахь салбар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэж ажиллалаа.




ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАЛТ:

"Монголын шилдэг уран зургууд" /Монголын уран зургийн галерейн алтан сан хөмрөгөөс дэлгэж буй Монголын түүх, соёлын хосгүй үнэт дурсгал болох Монголын дүрслэх урлагийн 30 орчим сор бүтээлүүдийг хамт олноороо тайлбарлагчийг тайлбартайгаар танилцлаа.



"Арт терапи -Урлагийн сэтгэл засал" хөтөлбөр – Сэтгэлийн нандин бүхнийг ил гаргаж өөрийн давуу тал, сайхан чанарыг нээх, өөрийгөө дотроосоо сонсох сэтгэл заслын хөтөлбөрт албан хаагчид хамрагдлаа.



“Хөгжимтэй зураг” - Уран зургийг хөгжимтэй хослуулан сонсгол болон хараагаараа дамжуулан өөрийн дотоод мөн чанар нуугдмал би-г сонсох хөтөлбөрт хамрагдлаа.



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР